



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2024 оны III улирлын тайлан

ХОЁРИРТЭЙХУТГА

Хоёр иртэй хутга

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27 хувиар нэмэгдлээ. Иргэдэд хэрэглээний зээл түлхүү олгогдсон бол боловсруулах салбараас бусад салбарт бизнесийн зээл өсөлттэй байна. Чанаргүй зээл буурч сүүлийн 10 жилийн доод түвшинд хүрчээ. Инфляцын түвшин тогтворжиж, төгрөгийн ханш тогтвортой байсны улмаас төгрөгийн хадгаламжийн өгөөж, валютын хадгаламжийн өгөөжөөс өндөр хэвээр байна.

Мөн уул уурхай, тээвэр, худалдаа болон үйлчилгээний салбарын идэвхжил нь эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлж эдийн засаг 5 хувиар өсөхөд чухал нөлөө үзүүллээ. Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ХАА-н салбар уналттай, бусад салбаруудын өсөлт харьцангуй сул байлаа.

Оны эхнээс эрдэс бүтээгдэхүүний экспорт өсөлттэй байсан бол нөгөө талдаа авто машины болон хөрөнгө оруулалтын зориулалттай бараа бүтээгдэхүүний импортын өсөлт өндөр байлаа.

Урсгал дансны алдагдал нь төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэхэд нөлөөлсөн бол гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулахад чухал нөлөө үзүүлжээ. Төсвийн үндсэн тэнцэл ашигтай гарч төсөвт ирэх дарамтыг бууруулж байна.

Уул уурхайн гаралтай эрдэс бүтээгдэхүүний үнэ болон тоо хэмжээний өсөлтийг өндрөөр таамаглан ирэх 2025 оны төсвийг тэлж байгаа нь ирэх жилүүдэд эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал ач холбогдолтой боловч нөгөө талаас импортыг дэмжих замаар инфляц, төлбөрийн тэнцэл болон төгрөгийн ханшид дарамт учруулах эрсдэл өндөр байна. Иймд төсвийн хэт их тэлэлт нь хоёр иртэй хутга шиг эргээд эдийн засгаа тэлэх боломжийг үгүйсгэх вий.




Банкуудын иргэдэд олгож буй зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Хэрэглээний зээл буюу цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээлийн эрэлт өндөр байна.
Малчдад олгосон зээлийн хэмжээ буурчээ.

Онцлох өөрчлөлт,
энгийн тайлбар



Онолын тодорхойлолт



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Шинээр олгосон зээлийн
хэмжээ нэмэгдэв.

30%



2024 оны III улирлын
гүйцэтгэл

2024 ОНЫ III УЛИРАЛД БАНКНЫ САЛБАРТ ГАРСАН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Банкуудын эзлийн өсөлт
үргэлжилсээр байна



Банкуудын зээлийн чанар
сайжирч байна.



Банкнудын өөрийн хөрөнгийн
өгөөж 20%-тай байна.



Системийн нөлөө бүхий 5
банкны санхүүгийн үзүүлэлт
өсөлттэй байна.



Банкуудын хувьцааны ханш бусад
салбартай харьцуулахад хямд байна.



Төгрөгийн хадгаламжийн өгөөж
валютын хадгаламжийн
өгөөжөөс өндөр байна.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2024 оны III улирал

Банкны салбарын зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Эдийн засаг сайжирч түүнийг дагаад бизнесүүдэд олгох зээл нэмэгджээ.
Иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.

+35%

Зээлийн үлдэгдэл
нэмэгджээ.


Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо



Эдийн засгийн салбаруудыг дэмжсэн бизнесийн зээл олголт эрчимжиж байна.

Уул уурхай болон барилгын салбар идэвхжиж ирсэн нь тус салбаруудад олгох зээлийн хэмжээ нэмэгдэхэд нөлөөлжээ. Худалдаа, үйлчилгээний салбарт олгож буй зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Бизнесийн зээл олголт, жил бүрийн III улирал



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Шинээр бизнесүүдэд олгосон зээл

36%

нэмэгджээ.

Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд
чанаргүй зээл


5.7%

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо


Чанаргүй зээлийн хэмжээ сүүлийн 10 жилийн доод түвшинд байна.

Өрхийн худалдан авах чадвар нэмэгдэж буй нь иргэдийн зээлийн чанарт эергээр нөлөөлж байна. Бизнесийн идэвхжил нэмэгдсэн нь чанаргүй зээлийн хэмжээг буурахад чухал нөлөө үзүүлээ. Уул уурхайн салбарт олгогдсон чанаргүй зээлийн харьцаа 2 дахин багасжээ.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн III улирал



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн III улирал




Төгрөгийн хадгаламжийн өгөөж өндөр байгаа нь төгрөгийн эх үүсвэр нэмэгдэхэд нөлөөллөө.

Төгрөгийн ханш тогтвортой байсан нь валютын харилцах болон хадгаламж буурахад нөлөөллөө. Төгрөгт итгэх итгэл нэмэгдсэн нь төгрөгийн харилцах болон хадгаламжийг нэмэгдүүллээ.

Банкны эх үүсвэр
Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Их наяд ₮

Банкны эх үүсвэр, жил бүрийн III улирал



Банкны эх үүсвэр
25%
нэмэгджээ.

Банкны жигнэсэн дундаж хүү


Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.

Хадгаламжийн хүү

11.5%

Хүүгийн түвшин тогтвортой байна.

Төв банк гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан аажмаар хүүгээ бууруулж буй хэдий ч хадгаламжийн хүү буурах төлөвгүй байна.



БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2024 оны III улирлын гүйцэтгэл

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий
банкнуудын актив

26%


ӨСӨВ.

Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 11.7 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Хасбанкны актив 30 хувиар, Голомт банк болон Төрийн банкны актив 28 хувиар, ХХБ-ны актив 25 хувиар тус тус нэмэгдсэн нь банкны салбарын активын өсөлтөд чухал нөлөө үзүүлжээ.

Банкуудын актив жил бүрийн III улиралд

Их наяд ₮




Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.7 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Хаан банкны эх үүсвэр 3 их наяд төгрөгөөр, ХХБ-ны эх үүсвэр 1.5 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Банкуудын эх үүсвэр, жил бүрийн III улирал

Их наяд ₮



Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкуудын эх үүсвэр

22%

нэмэгджээ.

Өөрийн хөрөнгийн өгөөж

Жич: Тухайн байгууллага нь өөрийн хөрөнгөө хэр үр ашигтай зарцуулж буй тухай мэдээлэл өгдөг. Өөрөөр хэлбэл компани хөрөнгийг хэрхэн ашиг болгож буйг илэрхийлдэг үзүүлэлт юм.

Банкуудын өөрийн
хөрөнгийн өгөөж дунджаар


19%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж хадгаламжийн өгөөжөөс илүү байна.

Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн дүн 6.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 20 хувиар өсжээ. Өөрийн хөрөнгөөр бий болгосон ашгийн хэмжээ өндөр хэвээр байна.


Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж, жил бүрийн III улирал



Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ буурчээ.

Банкууд эдийн засгийг дэмжих, гол салбаруудын өсөлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зээл олгох хангалттай өөрийн хөрөнгөтэй байна.

Банкнүүдын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн III улирал



2022	2023	2024
Хаан		
2022	2023	2024
ХХБ		
2022	2023	2024
Голомт		
2022	2023	2024
Төрийн банк		
2022	2023	2024
Хас		

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж

16%

Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий
банкуудын хөрвөх чадварын
харьцаа үзүүлэлтийн дундаж


38%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Системийн нөлөө бүхий 5 банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Банкууд цаашид эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хангалттай хэмжээний хөрөнгөтэй байна.

Банкнүүдын хөрвөх чадварын харьцаа, жил бүрийн III улирал



2022	2023	2024	2022	2023	2024	2022	2023	2024	2022	2023	2024	2022	2023	2024
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		


МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2024 оны III улирал: Эдийн засгийн өсөлт 5 хувьтай гарлаа. Оны эхнээс уул уурхайн салбар, түүнийг дагаад тээвэр, агуулахын салбарын идэвхжил өндөр байгаа нь эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлжээ. Хоёр шатны сонгууль нь худалдаа, үйлчилгээний салбарын өсөлтийг дэмжихэд нөлөөлжээ. Боловсруулах болон барилгын салбар нь аажмаар сэргэж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлж байна. Өнгөрсөн оны сүүлээс эхлэн цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан хөдөө, аж ахуйн салбар уналттай байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлжээ.

Төлөв байдал: АНУ болон БНХАУ-ын хоорондох технологийн өрсөлдөөн болон худалдааны дайн үргэлжлэх төлөвтэй байна. Дээр нь Хятадын эдийн засгийн нөхцөл байдал таагүй байгаа нь уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний үнэ буурах эрсдэлийг дагуулж байна. Ирэх 2025 онд уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнээс олох орлогыг өндрөөр төсөөлж төсвийг хэт их тэлж байгаа нь валютын ханш, төлбөрийн тэнцэл болон инфляцад дарамт учруулах эрсдэл өндөр байна. Иймд дунд хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэсэн уул уурхайн бус салбаруудыг дэмжсэн бодлогын арга хэмжээнүүдийг авах хэрэгцээ шаардлага улам нэмэгдэж байна.

2024 оны III улирлын байдлаар эдийн засаг 5 хувиар өсөв.

Хоёр шатны сонгууль нь худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжилийг дэмжиж эдийн засгийн өсөлтийн дийлэнх хувийг буюу 3.7 хувийг бүрдүүллээ. Уул уурхайн салбарын идэвхжил нь тээвэр, агуулахын салбарыг дэмжсэнээр эдийн засгийн өсөлтийн 2.3 хувийг бүрдүүлж байна. Барилгын салбар сэргэж байгаа бол ХАА-н салбар сүүлийн 4 улирал дараалан буурчээ.



Гадаад худалдааны тэнцэл ашигтай хэдий ч өмнөх оны мөн үеэс 30 хувиар буурчээ.

Зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдрийн баяжмалын экспорт нэмэгдсэн нь худалдааны тэнцэл ашигтай гарахад чухал үүрэг гүйцэтгэлээ. Суудлын автомашин болон хөрөнгө оруулалтын зориулалттай бусад бүтээгдэхүүний импорт нэмэгдсэн нь импорт ихээхэн өсөхөд нөлөөллөө.


Уул уурхайн гол бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дэх үнэ буурсан нь **экспортын өсөлт** саарахад нөлөөллөө.



Хөрөнгө оруулалтын зориулалттай бараа бүтээгдэхүүний **импорт өсөлттэй** байна.




Импортын өсөлт нь худалдааны тэнцлийн ашиг буурахад нөлөөллөө.




Төлбөрийн тэнцэл 251 сая ам.долларын алдагдалтай байна.

Экспортоос илүүтэйгээр импортолсон нь урсгал дансны алдагдлыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцэл алдагдалтай гарахад нөлөөллөө. Гадаадын хөрөнгө оруулалтын 575 сая ам.доллаар нэмэгдсэн нь санхүүгийн данс ашигтай гарахад чухал нөлөө үзүүлжээ. Төгрөгийн бодит ханш аажмаар суларч манай улсын бараа, бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад хямдхан болж байна.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш




Төлбөрийн тэнцэл



Импортын хэмжээ илүү байгаа ч хангалттай хэмжээний валютын нөөцтэй байна.

Оны эхнээс импортын бараа бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж, импортын тоо хэмжээ өссөн ч валютын нөөц хангалттай түвшинд байна.

Ирэх 2025 онд валютын нөөцөд дарамт учруулах эрсдэл харьцангуй бага байгаа хэдий ч төсвийн хэт тэлэлтээс үүдэлтэйгээр импортын хэмжээ нэмэгдэх хүлээлтийг бий болгоод байна.




Төсвийн тэнцэл 1.5 их наяд төгрөгийн ашигтай гарлаа.

Урсгал зардал тэр дундаа цалин хөлс болон бусад бараа бүтээгдэхүүний зардлын өсөлт нь төсвийн зарлагын дийлэнх хувийг бүрдүүлж байна.

Үндсэн тэнцэл ашигтай гарч төсвийн алдагдлын дарамт буурч байна.


Уул уурхайн салбарын сэргэлт нь төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлээ.



Уул уурхайн салбарын идэвхжил нь банкны салбарын өсөлтөд чухал нөлөө үзүүлдэг.

Эдийн засгийн мөчлөгийн дараагаар банкны салбарын өсөлт нэмэгддэг.

Технологийн шийдэл нь банкны салбарын өсөлтөд чухал нөлөө үзүүлж байна.



Банкны салбарын үр ашиг нэмэгджээ.

